



## ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2014 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 18

Улаанбаатар

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСЛИЙГ БАТАЛЖ, ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, Тахько (ХК) компанийн дүрмийн 7.1.18, Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмын 5.1, 5.2 дахь заалт, 2014 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулах төслийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай.
2. Тахько (ХК) компанийн "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-д өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт явуулж, шийдвэрлэхээр тогтоосугай.
3. Эчнээ санал хураалтыг 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс мөн оны 08 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд явуулахаар тогтоосугай.
4. Эчнээ санал хураалтад оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2014 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
5. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудсыг 2014 оны 06 дугаар сарын 20-ны дотор хувьцаа эзэмшигч (хувьцаа эзэмшигчдийн үйлчлүүлдэг үнэт цаасны брокер, диллерийн компанид)-д хүргүүлэх, саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2014 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 17.00 цагаар тогтоосугай.
6. Эчнээ санал хураалтын саналын хуудасны агуулга, загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
7. Эчнээ санал хураалт явуулах ажлыг зохион байгуулах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын даргад:	Б.Батхуяг	ТУЗ-ийн гишүүн
Гишүүдэд	С.Итгэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Ц.Доржготов	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
8. Эчнээ санал хураалт явуулах ажлыг зохион байгуулах комисст даалгах нь:
  - Эчнээ санал хураалт явуулах тухай нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд хүргэх зар мэдээг 2014 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн өдөр тутмын 2-оос доошгүй сонинд нийтлүүлж, телевиз, компанийн болон Хөрөнгийн биржийн цахим хуудас, бусад мэдээллийн хэрэгсэлээр мэдээлэх;
  - Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа дээрх журмын дагуу дахин мэдээлэх.
  - Эчнээ санал хураалт явуулах тухай мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж (ХК) компанид 2014 оны 06 дугаар сарын 13-ны дотор хүргүүлэх;
  - Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал, гарах шийдвэрийн төслийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авах ажлыг үнэт цаасны зах зээлийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий брокер, диллерийн компанитай гэрээ байгуулж, гэрээний дагуу зуучлуулан зохион байгуулах;
  - Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал, шийдвэрийн төслийн танилцуулга, санал авах хуудсыг тэдний үйлчлүүлдэг брокер, диллерийн компанид тогтоосон хугацаанд хүргүүлэх;



- Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудал, шийдвэрийн төсөл болон санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбогдол бүхий бусад мэдээллийг 2014 оны 06 дугаар сарын 20-ны өдрөөс мөн оны 08 дугаар сарын 08-ны өдөр хүртэл хугацаа (09-13, 14-17 цагийн хуваариар)-нд компанийн байр (Нийслэлийн Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, Самбуугийн гудамж-18 хаяганд байрлах офиссын байр)-нд хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах;
  - Эчнээ санал хураалтын саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацаа дууссаны дараа санал авсан болон ирүүлсэн саналын хуудсыг бүртгэлийн хамт Тооллогын комисст хүлээлгэн өгөх;
  - Тооллогын комиссын тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах;
  - Тооллогын комиссын тайланг үндэслэн гарсан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг Тооллогын комиссын шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх;
  - Эчнээ санал хураалтаар гарсан шийдвэр, холбогдох баримт бичгийг хууль тогтоомжид заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж (ХК) компанид хүргүүлэх;
9. Эчнээ санал хураалтын Тооллогын комиссын даргаар Д.Минжмаа, гишүүнээр Э.Чулуунтогтох, Н.Гомбосүрэн нарыг томилж, эчнээ санал хураалтын тооллогын дүнгийн тайлан, тооллогын комиссын шийдвэрийг саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор гаргаж, Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг комисст даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ДАРГА



Д.БУЯНБАТ

